

Байгалийн ургамал, амьтныг хамгаалах талаар
авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Тэргүүн, гишүүд “Байгалийн ургамал, амьтны өнөөгийн төлөв байдал, цаашид авах арга хэмжээ”-ний тухай Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайд С.Оюуны илтгэлийг ажлын журмаар хэлэлцээд ЗӨВЛӨМЖ болгох нь:

Нэг. Улсын Их Хуралд:

1. Бэлчээр ашигласны төлбөр тогтоох, эзэмшүүлэх, зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх, хариуцлага хүлээлгэх чиглэлээр эрх зүйн орчныг бүрдүүлэх;
2. Генийн нөөцийг хамгаалах, ашиглах эрх зүйн орчныг бүрдүүлэх.

Хоёр. Засгийн газарт:

1. Биологийн олон янз байдлыг хамгаалах үндэсний хөтөлбөр, үйл ажиллагааны төлөвлөгөөг шинэчлэн боловсруулан баталж, хэрэгжүүлэх;

2. Байгалийн нөөц баялгийг хамгаалах, зохистой ашиглах бодлогын шийдвэрийг шинжлэх ухааны үндэслэлтэй, тооцоо судалгаан дээр суурилан оновчтой гаргах үүднээс бодлогын болон технологийн судалгааны төвийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд байгуулж ажиллуулах;

3. Амьтан, ургамал, бичил биетний зүйлийн олон янз байдал, популяцийн төлөв байдалд дэвшилтэт арга технологиор хяналт-шинжилгээ хийх улсын сүлжээ байгуулж ажиллуулах;

4. Байгалийн ургамлыг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах, эмийн түүхий эдийн зориулалтаар бэлтгэж экспортлохыг хязгаарлах, онцгой ач холбогдолтой эмийн ургамлыг тариалах шинэ технологи, агротехникийн дэвшилтэт арга боловсруулах санаачилгыг дэмжсэн эрх зүйн орчин, эдийн засгийн хөшүүрэг бий болгох;

5. Бэлчээрийн одоогийн төлөв байдал, цаашдын хандлагад суурилсан бэлчээрийн даацыг байгалийн бүс бүрээр шинэчлэн тогтоож, түүний хүрээнд малын тоо толгой, төрөл, сүргийн бүтцийн зохистой харьцааг хангах арга хэмжээ авч бэлчээрийг өнжөөх, сэлгээх боломжийг бүрдүүлэх.